



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

САНГИЙН ЯАМ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт

*Улсын Их Хурлын 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн
чуулганаар батлагдсан хуулийн нэмэлт, өөрчлөлт*

Нэмэлт, өөрчлөлтийн шаардлага



Төрийн худалдан авалт импортын бараанаас хараат болсноор дотоодын бараа өрсөлдөөнд ялагдсан тул үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, чанар, стандарт хангасан үр ашигтай худалдан авалт шаардлагатай болсон.

Тендер шалгаруулалтад хугацаа их зарцуулдаг шалтгааны нэг нь тендерт оролцогчид үндэслэлгүй гомдол гаргаж бүтээн байгуулалтын ажил хугацаандаа хэрэгжихгүй байдал жил ирэх тусам ихэссэн.

Цахим худалдан авалтыг боловсронгуй болгох замаар худалдан авах ажиллагааг ил тод болгож нийтлэг алдаа дутагдлыг арилгах шаардлага үүсч, хариуцлагыг нэмэгдүүлэх бодит хэрэгцээ бий болсон.

Сангийн яамнаас оруулж буй хоёрдох удаагийн нэмэлт, өөрчлөлт.

Хуулийн үйлчлэх хүрээ

- Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээл дээр үнэт цаас гаргах, арилжаалах, олон улсын зах зээл, банк, санхүүгийн байгууллагаас арилжааны нөхцөлтэй зээл авахтай холбоотой үйлчилгээ худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.”



Зохицуулагдаагүй
харилцааг нэмэв



Үйлчлэх хүрээг
нэмэв

- Хуулийн 3 дугаар зүйл:

~~3.6. Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.~~

~~3.7. Зөвлөлдөх санал асуулга болон сонгуулийн төв байгууллагаас Сонгуулийн тухай хуулийн 38.1 д заасан төсвийн хүрээнд сонгууль зохион байгуулахтай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.~~

~~3.8. Ирээдүйн өв сан, Ирээдүйн өв сан корпорацийн үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.~~

Цахим тендер шалгаруулалтыг бэхжүүлнэ

- Цахим программ хангамжийг ашиглан худалдан авах ажиллагааг төлөвлөх, тендер шалгаруулалтыг зохион байгуулж, тайлагнах, хяналтыг улам бүр хөгжүүлнэ.
- Компаниуд тендерт оролцоход хялбар болж, бүртгэлийн санг хөтөлнө.



- Өдөр тутам давтагддаг барааны нэгж үнэд үндэслэн Засгийн газрын цахим дэлгүүрийг бий болгон төрийн байгууллагууд 3 хүртэл жилийн хугацаанд тухайн барааг худалдан авна.
- Төрийн байгууллагууд цахим дэлгүүрээс өдөр тутмын жижиг барааг худалдан авна.

Төрд ажил гүйцэтгэсэн аж ахуйн нэгжийн бүртгэлийг ил болгоно.

Мэргэжлийн байгууллага байгуулна

- Яамд болон төрийн байгууллагууд цаашид зөвхөн тухайн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардагдах бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг зохион байгуулна.
- Худалдан авах ажиллагааны бие даасан байгууллага улсын болон бүс нутгийн чанартай тендер шалгаруулалтыг зохион байгуулна.
- Аймаг, нийслэл, дүүрэг бие даасан албатай байна.



Тендерийг
мэргэжлийн
байгууллага
зарлана



Ногоон
худалдан авалт

- Төрийн байгууллагууд байгальд ээлтэй шалгуур үзүүлэлтийг худалдан авах бараа, ажил, үйлчилгээний шаардлагад оруулах замаар төр ногоон хөгжлийн бодлогыг дэмжинэ.
- Тендерийн үндсэн шалгуурыг Монгол Улсын болон олон улсын стандарт үндэслэн боловсруулж, чанартай бараа худалдан авна.

Урьдчилсан худалдан авах ажиллагаа

- Захиалагч гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар сонгон шалгаруулж болно.
- Сангийн сайд журам батална.
- Засгийн газар Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулах улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээний жагсаалтыг батална.
- Урьдчилсан худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтад шалгарсан тендерт оролцогчтой тухайн зээл, тусламжийн олон улсын гэрээ, улсын төсвийн санхүүжилт батлагдаагүй тохиолдолд гэрээ байгуулахыг хориглоно.
- Энэ хуулийн 29.4-т заасан тендерийн хүчинтэй байх хугацаа өнгөрснөөс хойш энэ хуулийн 29.6-д заасан зээл, тусламжийн олон улсын гэрээ, улсын төсвийн санхүүжилт батлагдсан тохиолдолд тухайн тендер шалгаруулалтыг хүчинтэйд тооцно.



Урьдчилсан
худалдан авах
ажиллагаа

Үндэсний үйлдвэрлэлийг дэмжинэ

- Дотоодын үйлдвэрээс худалдан авах боломжтой барааг импортын бараанаас тусад нь салган Засгийн газар Монгол Улсын гарал үүсэлтэй барааны жагсаалтыг тухай бүр баталж, уг жагсаалтад багтсан барааны хувьд тендер шалгаруулалтыг зохион байгуулна.
- Дотоодын үйлдвэрийн барааг импортын бараанаас тусад нь багцлах.
- Дотоодын үйлдвэрлэлээр хангах барааны тендер шалгаруулалтад гадаадын этгээдийг оролцохыг хориглоно. Зөвхөн дотоодын үйлдвэрлэгчид жагсаалтад багтсан барааг нийлүүлнэ.
- Засгийн газар дотоодын үйлдвэрлэлээс худалдан авах барааны жагсаалтыг баталсан тогтоолын хэрэгжилт, үр дүнд жил бүр үнэлгээ, шинжилгээ хийж, шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр оруулна.



Дотоодын
барааны
жагсаалт



Давуу эрхийн
зөрүүг олгоно

- Тендерт оролцож буй тендерт оролцогч нарт дотоодын давуу эрхийн зөрүүг хуульд заансы дагуу заавал олгоно. Тендерт оролцогчийн ажиллах хүчний 30 хүртэл хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд бүрдүүлж байгаа бол давуу эрх олгоно.

Тендерийг богино хугацаанд хийнэ

- Бүх тендерийн хариу 23 хоногт багтан гарч, шалгарсан оролцогчтой 30 хоногт багтаан гэрээ байгуулж, ажил эхэлнэ.
- Шаардлагатай тохиолдолд дээрх хоногийг 30 хоногоор сунгадаг байсныг өөрчилж, 15 хоногоор сунгана.
- Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын **6-аас** доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна.



Тендерийн
хугацаа
багасна



Харилцааг
уялдуулсан

- Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, **худалдан авах ажиллагааны цахим систем болон** хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.
- Захиалагч энэ хуулийн 22.3-т заасан хүсэлтийн хуулбарыг түүнд өгсөн хариу тодруулга, нэмэлт мэдээллийн хамт тендерийн баримт бичиг худалдан авсан бүх сонирхогчдод нэгэн зэрэг бичгээр илгээх бөгөөд уг бичгийг шуудангийн байгууллагад хүлээлгэн өгснөөр, **эсхүл худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлснээр** хариу тодруулга, нэмэлт мэдээллийг хүргүүлсэнд тооцно.

Тендерийн үнэлгээ

- Зөвхөн чанарын шалгуур хангасан тендерт оролцогчдын үнэд харьцуулалт хийж гүйцэтгэгчийг сонгоно.
- Чадварын шаардлагыг хангаж, хуульд заасны дагуу үнэлэгдсэн тендерүүдийг бага харьцуулах үнэтэйгээс их харьцуулах үнэтэй рүү нь эрэмбэлж, хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгоно.
- Зөвлөх сонгох тендер шалгаруулалт 2 хоёр удаа амжилтгүй болсон тохиолдолд шууд гэрээ байгуулж болно.



Чанартай



Давхардалгүй

- Төрийн аудитын асуудал эрхэлсэн болон төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийн давхардлыг арилгаж, хийх ажлыг тодорхой болгов.

Хууль 2019 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжинэ.

Харьцуулалт

- Үнийн санал ирүүлэх урилгыг худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх;
- Харьцуулалтын үнийн санал ирүүлэх хугацааг урилга **зарласан** өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй хоногоор тогтооно.
- Харьцуулалт амжилтгүй болвол дахин харьцуулалт зохион байгуулна.



Чанартай



Давхардалгүй

- Хүнсний аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлагаар чанарын шаардлага хангасан тарианы үрийг үйлдвэрлэгчээс авах бол.

Гэрээний талуудыг хариуцлагажуулна



Тендерийг ил
болгоно

- Цахим тендерт оролцогчид бусад оролцогчдын илгээсэн материалыг харах боломжтой болж, тендер шалгаруулалтын зохион байгуулалтын талаарх хардлагыг арилгах, үнэлгээг хянах боломжтой болно.
- Төрийн байгууллага байгуулсан гэрээний хувийг олон нийтэд ил болгоно.

- Төртэй байгуулсан гэрээний үүргээ зөрчсөн, гэрээнд заасны дагуу ажил, бараа, үйлчилгээгээ хийж гүйцэтгээгүй хувь хүн, аж ахуйн нэгжийг **ХАР ЖАГСААЛТ**-д хамруулж, цаашид гэрээ байгуулах эрхийг хязгаарлана.
- Үндэслэлгүй гомдол гаргаж төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацааг удаашруулдаг тендерт оролцогчдыг хариуцлагажуулах зорилгоор тендерийн баталгааг барьцаална. Гомдлоо нотлох баримттай гаргана.



Хариуцлагыг
нэмэгдүүлнэ

Гомдол гаргах



Хариуцлагыг
нэмэгдүүлнэ

- Тендерт оролцогч нь энэ хуулийн 11.2-т заасныг зөрчсөн болон тендерийн баримт бичиг бэлтгэх явцад өрсөлдөөнийг хязгаарласан ямар нэгэн зөрчил гарсан гэж үзвэл гомдлоо тендерийн нээлт хийхээс **ажлын 10-аас доошгүй өдрийн** өмнө Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт, захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн, хуульд заасан хугацаанд захиалагч шийдвэр гаргаагүй, эсхүл гэрээ байгуулах эрх олгосон тухай гомдлыг зөвхөн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус ажлын 5 өдрийн дотор гаргана.
- Тендерт оролцогчдын гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ хуулийн 20.7.3-т заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгох дээд хэмжээ 20 сая төгрөгөөс хэтрэхгүй байна. Гомдлыг үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн бол тендерийн баталгааг буцаан олгоно.

Энэ хуулийг 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.